МИАТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/85 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо, соёлыг сайжруулах зорилгоор “Нислэг-үйлдвэрлэлийн нэгжүүдийн удирдах болон ахлах ажилтнуудын аюулгүй ажиллагаатай холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмын дагуу нислэг-үйлдвэрлэлийн нэгжүүдийн удирдах болон ахлах ажилтнуудын аюулгүй ажиллагаатай холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн саналаа тухай бүр нь танилцуулж ажиллахыг Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны дарга /Д.Цогтгэрэл/-д даалгасугай.

3.Аюулгүй ажиллагааны заавар, дүрэм, журмыг хэрэгжүүлж хариуцсан нэгж, ажилтнуудынхаа үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллахыг нийт захирал, хэлтэс, нэгжийн дарга болон ахлах ажилтнуудад үүрэг болгосугай.

4.Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Т.Мөнгөн/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. МӨНХТАМИР

“МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024
оны 02.-р сарын ..19..-ны өдрийн A/85 тоот
тушаалын хавсралт

“МИАТ” ТӨХК-ИЙН НИСЛЭГ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НЭГЖҮҮДИЙН УДИРДАХ БОЛОН АХЛАХ АЖИЛТНУУДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь “МИАТ” ТӨХК /цаашид “компани” гэнэ/-ийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо, соёлыг сайжруулах, ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан компанийн нислэг-үйлдвэрлэлийн нэгж, түүний удирдлага, ахлах ажилтнуудын аюулгүй ажиллагаатай холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Аюулгүй ажиллагаатай холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхтэй холбоотой харилцаанд бодитой байх, шалгуур хангасан байх, заавар, журмын хүрээнд хязгаарлалт тавигдаагүй бол ил тод, нээлттэй байх, үйл баримтад тулгуурласан, нотлох баримттай байх, шударга байх зарчмыг тус тус баримтална.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Компанийн “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны заавар”-ын 2.4.17-д заасан компанийн хэмжээнд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд үүрэг хүлээсэн албан тушаалтнууд буюу нислэг-үйлдвэрлэлийн нэгжийн удирдлага, ахлах ажилтнуудын үйл ажиллагаанд хамаарна.

ГУРАВ. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ доор дурдсан үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

3.1.1. Компанийн Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын алба /цаашид “ААЧНАБА” гэнэ/-нд хариуцсан хэлтэс, нэгжийн ажилтнуудаас аюулгүй ажиллагааны мэдээллийн сувгуудыг ашиглаж ирүүлсэн мэдээллийн тоо болон мэдээллийн чанар, аюулгүй ажиллагааны мэдээллийг дэмжиж, сурталчилдаг байдал **/Safety reporting/**;

3.1.2. Хариуцсан хэлтэс, нэгжийн ажилтнууд нь аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг даган биелүүлж байгаад хяналт тавих, зохих сургалтуудад хамрагдсан эсэх, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журам, зааврыг зөрчсөн асуудал гарсан эсэх, шалтгааныг тогтоож залруулах болон давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал **/Analysis of irregularities/**;

3.1.3. Аюулгүй ажиллагааны мэдээллийн сувгуудаар ирсэн мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах, “Action log” програм ашиглан эрсдлийн үнэлгээ хийсэн байдал, эрсдлийг бууруулах арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлсэн байдал **/Risk management/**;

3.1.4. Гадаад болон дотоодын аудитаар илэрсэн үл тохирлыг засах болон залруулах арга хэмжээ хугацаандаа хаасан байдал **/Safety assurance/**;

3.1.5. Өөрчлөлтөөс үүсч болох аюулыг илрүүлэх, аюулаас үүсэх эрсдлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах арга хэмжээг авсан байдал **/Change management/**;

3.1.6. Аюулгүй ажиллагааны Ажлын хэсгийн хурлуудыг цаг хугацаанд нь хуралдуулсан эсэх, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бүрэн хэлэлцсэн эсэх,

тухайн хурлаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлсэн байдал **/Safety action group/**;

3.1.7. Аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сайжруулсан, компанийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлтэд оновчтой шинэ санаа гаргасан байдал **/Safety performance indicator/**.

3.2. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хагас жилд нэг удаа 3.1-д заасан үзүүлэлтүүдийн биелэлтээр ААЧНАБА-наас хийж гүйцэтгэнэ.

ДӨРӨВ. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛ

4.1. Ажлын гүйцэтгэлийг дүгнэхдээ "0-100" гэсэн онооны системийг баримтлах ба гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт тус бүрт харгалзах оноог өгнө.

4.2. Ажлын гүйцэтгэлийг дүгнэхдээ доорх хүснэгтэд заасан аргачлалыг баримтална:

№	Үндсэн үзүүлэлт	Гүйцэтгэлд хүрэх хэмжүүр	Авбал зохих оноо*
1.	Журмын 3.1.1. /Safety reporting/	Хариуцсан хэлтэс нэгжийн ажилтнуудаас ирүүлсэн аюулгүй ажиллагааны мэдээллийн тоог нийт ажилтнуудын тоонд харьцуулсан үзүүлэлт	20 оноо
2.	Журмын 3.1.2. /Analysis of irregularities/	Хариуцсан хэлтэс нэгжийн ажилтнууд нь стандарт дүрэм журам дагаж мөрдсөн байдал, зөрчил гаргасан бол учир шалтгааныг тогтоож залруулах болон сэргийлэх арга хэмжээ авсан байдал	20 оноо
3.	Журмын 3.1.3. /Risk management/	Action log програмд бүртгэгдсэн аюулыг цаг хугацаанд нь үр дүнтэй хаасан байдал	20 оноо
4.	Журмын 3.1.5. /Safety assurance/	Аудитаар илэрсэн үл тохирол, зөвлөмжийн тоог шалгагдсан стандартын тоонд харьцуулсан үзүүлэлт	10 оноо
5.	Журмын 3.1.6. /Change management/	Өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийг оновчтой тодорхойлсон байдал, өөрчлөлтийн дараа асуудал гарсан эсэх	10 оноо
6.	Журмын 3.1.7. /Safety action group/	Улирал бүр SAG meeting хугацаандаа хуралдуулсан байдал, хурлын шийдвэрийн хэрэгжилтийн үзүүлэлт	10 оноо
7.	Журмын 3.1.8. /Safety performance indicator/	Аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн зорилтод хүрсэн эсэх, зорилтдоо хүрээгүй үед засах арга хэмжээ авсан эсэх, SPI оновчтой тодорхойлж, сайжруулалт хийж байгаа байдал	10 оноо

Тайлбар:

1. 90-100 оноо авсан бол "Маш сайн"
2. 80-89 хүртэлх оноо авсан бол "Сайн"
3. 70-79 хүртэлх оноо авсан бол "Хангалттай"
4. 60-69 хүртэлх оноо авсан бол "Дутагдалтай"
5. 0-59 хүртэлх оноо авсан бол "Хангалтгүй"

* Авбал зохих онооны задаргаа, тайлбарыг энэхүү журмын хавсралтын дагуу хийнэ.

4.3. Нислэг-үйлдвэрлэлийн нэгжийн удирдлага, ахлах ажилтан нь багадаа 60 оноо авах шаардлагатай бөгөөд хэрвээ 60-аас бага оноо авсан тохиолдолд шалтгаан

нөхцөлийг ААЧНАБА-аас тодруулж засаж залруулах хугацаатай ажлыг зохион байгуулна.

4.4. ААЧНАБА-аас тогтоосон хугацаанд шалтгаан нөхцөлөө арилгаж оноогоо нэмээгүй тохиолдолд 60-аас бага оноо авсан удирдлага, ахлах ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

4.5. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хагас жилд /7-р сар болон 1-р сард/ багтаан гаргаж, оноогоор тэргүүлсэн нэгжийн удирдлага 1, ахлах ажилтан 1, нийт 2 албан тушаалтан **/Best risk manager/**-д нэмэлт ажил, үүрэг гүйцэтгэсэнтэй холбогдуулан үндсэн цалингийн 40%-тай тэнцэх хэмжээтэй нэг удаагийн нэмэгдэл хөлс олгоно.

---oOo---

Нийт авбал зохих онооны задаргаа, тайлбар

Safety reporting 20	**Safety irregularities 10**	**Risk management 20**	**Safety assurance 10**	**Change management 10**	**Safety meeting 10**	**SPI 20**
Number of voluntary hazard report and maintenance error report	Number of rule breaking, maintenance error, occurrence, incident	Percentage of closed risks out of registered	On time effective finding closure rate	Rate of managed risks associated with changes	Number of Safety action group meeting	Achievement rate of safety targets
40% of employee=20 points 30% =15 points 20% =10 points 10% =5 points	1 occurrence= (-1 point)	Action log closed status 100%=20 points 90%=15 points 80%=10 points 70%=5 points	On time finding closure=10 points Overdue findings=5 points	Identification of hazard=5 points Effective risk mitigation actions=5 points	1 on time SAG meeting= 2.5 points	1 Yellow SPI= (-1 point) 1 Red SPI= (-3 points)